



“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК” ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Худалдаа, хөгжлийн банк ("ХХБ") нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг дунд хугацааны Бизнес төлөвлөгөөний зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтод зарцуулахаар төлөвлөсөн билээ. Ингэхдээ "Ногоон банк" болох урт хугацааны тэргүүлэх дэд стратеги чиглэлийн хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжилт олгох юм. Анхдагч зах зээлийн арилжаанд нийт 2'528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилтот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр хаагдсан.

Банк нь активын зохистой бүтцийг бий болгох, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд тэлэлт хийх стратеги төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтыг бизнесийн сегментүүдэд дараах хуваариар төлөвлөсөн байна. Үүнд:

- **I. Байгууллагын сегмент: 50.0%** • **II. Жижиг, дунд бизнесийн сегмент: 20.0%** • **III. Иргэдийн сегмент: 30.0%**

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт (2023.05.28-2023.12.31-ний өдрийг дуустал хугацаанд олгосон зээлээр):

НИЙТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДҮН	MNT 83,500,000,000.00
- Үүнээс Байгууллагын сегментэд олгох дүн	MNT 41,750,000,000.00
- Үүнээс Жижиг, дунд бизнесийн сегментэд олгох дүн	MNT 16,700,000,000.00
- Үүнээс Иргэдийн сегментэд олгох дүн	MNT 25,050,000,000.00
НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН:	MNT 46,896,883,965.00
ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУВЬ:	56.16%

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт (2023.10.01-2023.12.31-ний өдрийг дуустал хугацаанд олгосон зээлээр):

	Зээлийн тоо	Зээлийн дүн	Нийт зээл олголтод эзлэх хувь (зээлийн дүнгээр)	Нийт IPO эх үүсвэрийг бизнесийн сегментүүдэд хуваарилсан хэмжээнд эзлэх хувь
НИЙТ	248	MNT 34,597,441,575.00	100.00%	
Б. Зээл олгосон бизнесийн сегментээр:				
I. Байгууллагын сегмент	6	MNT 4,370,000,000.00	12.63%	10.47%
II. Жижиг, дунд бизнесийн сегмент	65	MNT 13,971,000,000.00	40.38%	83.66%
III. Иргэдийн сегмент	177	MNT 16,256,441,575.00	46.99%	64.90%